

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.09.24-09.28

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн Dow Jones болон S&P 500 индексүүд уналттай хаагдсан бол Nasdaq индекс өсчээ. S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл технологи болон тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өссөн бол санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

Долоо хоногийн эхээр БНХАУ-ын эрх баригчид АНУ-тай худалдааны хэлэлцээр хийхээс татгалзаж, хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч эхэлсэн.

Илон Маск “Twitter” хуудсаараа дамжуулан “Tesla” компанийг хувийн өмчит болгохоо зарласантай холбогдуулан АНУ-ын Үнэт цаасны хороо түүнийг шүүхэд өгсөн байна. Түүнийг “Бодит үндэслэлгүй мэдээлэл олон нийтийн сүлжээгээр цацаж, хөрөнгө оруулагчдыг төөрөгдүүлж, хувьцааны ханшид нөлөөлсөн” гэж буруутгажээ. Ингэснээр тус компанийн хувьцааны ханш 12 хувиар унасан байна.

Энэ долоо хоногт АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж, 2.25 хувь болголоо. Тус банк он гарснаас хойш бодлогын хүүг гурван удаа нэмж байгаа бөгөөд хүүгийн түвшин 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн өндөр түвшинд хүрээд байна.

Европ: Итали улсын Засгийн газар 2019 оны төсвийн алдагдалыг 3 дахин ихээр буюу 2.4%-тай тэнцэхээр баталсан явдал Европын хөрөнгийн зах зээлийн индекст сөргөөр нөлөөлөв. Энэхүү шийдвэр нь Европын холбооноос Итали улсад тавьж буй төсвийн зарлагаа танах шаардлагыг зөрчиж байгаа юм. Ингэснээр Италийн зээлийн зэрэглэл буурах эрсдэлтэй билээ. Мөн еврогийн ханш ам.долларын эсрэг 1 орчим хувиар суларчээ.

Европын бүсийн дотоодын хэрэглээ болон бизнесийн итгэлцлийн индекс 9 сарын турш унав. Худалдааны бодлогын тодорхой бус байдлаас шалтгаалж экспортын хэмжээ буурч, түүнийг дагаад аж үйлдвэрлэлийн гарц буурсан байна.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн индекс өсөлттэй хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг чангарч, 113.43 болов.

Усан онгоцны үйлдвэрлэл, усан замын тээвэр, уул уурхайн салбарт үйл ажиллагаагаа явуулж буй компаниудын хувьцааны ханш өссөн бол авто машин үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

БНХАУ: БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын компаниудын ашгийн өсөлт 8-р сард сүүлийн таван сарын доод түвшинд хүрч саарлаа. Дээрх салбарын компаниудын ашиг өнгөрсөн сард жилийн дүнгээр 9.2 хувиар өсөж, 519.6 тэрбум юань буюу 76 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь ашгийн өсөлт дөрөв дэх сардаа дараалан саарсан төдийгүй, өмнөх сарын өсөлт бараг хоёр дахин буурсан үзүүлэлт боллоо.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,330.82	1.95% ▲
Dow Jones	АНУ	26,458.31	-1.07% ▼
S&P 500	АНУ	2,913.98	-0.54% ▼
Nasdaq	АНУ	8,046.35	0.74% ▲
S&P/TSX	Канад	16,073.14	-0.93% ▼
FTSE 100	Их Британи	7,510.20	0.27% ▲
S&P/ASX 200	Австрали	6,172.60	-0.36% ▼
Nikkei 225	Япон	24,120.04	1.05% ▲
Hang Seng	Хонг Конг	27,788.52	-0.59% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.78
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.50
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.77
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.29
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.44
TDBM' 2020	USD	9.3%	106.12

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.261	0.04 ▲
Libor 3M	2.398	0.03 ▲
Libor 6M	2.604	0.01 ▲
Libor 1YR	2.919	0.01 ▲
US 6M Bond	2.359	-0.01 ▼
US 2YR Bond	2.823	0.02 ▲
US 3YR Bond	2.891	0.00 ▲
US 5YR Bond	2.961	0.01 ▲
US 10YR Bond	3.069	0.01 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.09.28	Өөрчлөлт
USD	2,552.13	1.22% ▲
CNY	370.83	0.61% ▲
EUR	2,965.19	-0.11% ▼
RUB	38.90	2.23% ▲
KRW	2.30	1.77% ▲
JPY	22.50	0.58% ▲
CAD	1,961.37	0.40% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,190.47	-0.50% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.64	2.81% ▲
Зэс	USD/lb.	280.20	-1.16% ▼
Нүүрс	USD/MT	114.40	2.19% ▲
WTI газрын тос	USD/bbl.	73.49	2.78% ▲
Brent газрын тос	USD/bbl.	83.06	4.23% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	3.02	2.03% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VIII	6.00%
Бодлогын хүү	2018. VIII	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VIII	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VIII	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VIII	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 44 компанийн 1,731.6 сая төгрөгийн 1,847,238 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсч 92 төгрөгт хүрч хаагдсан бол “Багануур” /BAN/ компанийн хувьцаа 15.73%-аар буурч 1,350 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 1,000 ширхэг үнэт цаас 100.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.


9-р сарын 28-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,347.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,330.82 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.95%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,831.6
Зах зээлийн үнэлгээ	2,347,481.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,330.82	1.95% ▲
MSE I индекс	9,582.43	0.52% ▲
MSE II индекс	8,884.00	-0.88% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Махимпекс	420,379	1,006,384,887
Хархорин	101,634	142,287,600
Мандал даатгал	26,091	129,861,145
Говь	2,826	92,398,460
АПУ	154,868	89,709,513

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	92.00	15.00% ▲
Ган хэрлэн	4,413.00	14.98% ▲
Алтайн зам	13,010.00	14.93% ▲
Талх чихэр	22,820.00	14.10% ▲
Хэрлэн хивс	94.00	10.59% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Багануур	1,350.00	-15.73% ▼
Шивээ овоо	1,700.00	-15.00% ▼
Могойн гол	5,530.00	-14.86% ▼
Женко тур бюро	60.00	-14.29% ▼
Авто импекс	1,900.00	-11.63% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	9,516,645,296
Ард секюритиз	2,153,049,854
Новел инвестмент	583,702,113
Голомт капитал	346,589,501
Монсек	242,592,592

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	568.50	604,987
Таван толгой	7,340.00	386,563
Говь	33,520.00	261,494
МИК	10,980.00	227,388
Сүү	223.16	76,767

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	1,000	100,000,000	100,000	100,000	104	14.820%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дютти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Ард даатгал” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 2018.10.01-нд эхэлнэ

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 9-р сарын 27-ны өдрийн 1/3857 тоот албан бичгийн дагуу олон нийтэд шинээр үнэт цаасаа санал болгон арилжаалсан “Ард даатгал” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр боллоо.

Тус компани нь нийт хувьцааныхаа 30% буюу 7,500,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018 оны 9-р сарын 17-ний өдрөөс 9-р сарын 26-ны өдрийн 15:00 цаг хүртэл авч дууссан.

“Ард Даатгал” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд 1,367 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 9,954,848 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 32.7 хувиар давсан үзүүлэлт болжээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Материал импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Материал импекс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 01 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.11.02-ны өдрийн 10:30 цагт

Бүртгэх өдөр: 2018.10.12-ны өдөр

Хуралдах газар: БГД-ийн 4-р хороо, Нарны зам 16/5, “Материал импекс” ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. “Материал Импекс” ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулах эсэх;
2. ББСБ үүсгэн байгуулах бол дүрэмд өөрчлөлт оруулах.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ажлын өдрүүдэд БГД-ийн 4-р хороо, “Материал импекс” ХК-ийн байранд ирэх эсхүл харилцдаг “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хурал зохион байгуулах комисс: 7007-9924, 9605-1933.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг нэгдсэн байдлаар шинэчиллээ

Хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нөлөөлөх гол мэдээллүүдийн нэг нь тухайн хувьцаат компанийн нөлөө бүхий буюу 5-аас дээш хувь эзэмшигчдийн мэдээлэл байдаг билээ. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь энэхүү мэдээллийг олон улсын жишгийн дагуу ил тод, нээлттэйгээр хөрөнгө оруулагчдад мэдээлэх, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.7 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хэрэгжилтийг хангуулахад анхааран ажиллаж байна.

Үүний хүрээнд нийт хувьцаат компаниудын 2018 оны 7-р сарын 31-ний өдрийн байдлаар бүртгэлтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг Монгол, Англи хэл дээр нэгдсэн байдлаар шинэчлэн цахим хуудсандаа байршууллаа.

Энэхүү мэдээлэлтэй танилцахыг хүсвэл “Бүртгэлтэй ХК” ерөнхий цэснээс сонирхож буй компани сонгон орж, Ерөнхий мэдээлэл дэд цэсний “Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид” хэсгийг үзнэ үү.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллахаар боллоо

Монголын хөрөнгийн бирж болон Зээлийн батлан даалтын сан нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн гаргах өрийн хэрэгсэл буюу бондод батлан даалт гаргах эрх зүйн орчин бүрдүүлэх, үнэт цаасны зах зээлд батлан даалттай шинэ бүтээгдэхүүн бий болгох талаар хамтран ажиллах, мэдээлэл солилцох чиглэлээр санамж бичиг байгууллаа. Энэхүү үйл явдлыг тохиолдуулан Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Б.Батбаяр Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10-р сарын 01-ний өдрийн үнэт цаасны арилжааг нээж, цанг цохих ёслолд оролцлоо.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд хувьцааны арилжаа идэвхжиж, шинээр болон нэмж хувьцаа гаргах үйл ажиллагаа амжилттай явагдаж байна. Хөрөнгийн зах зээлийн цаашдын тогтвортой хөгжлийг хангахын тулд хувьцаанаас гадна хөрөнгийн зах зээлийн үндсэн бүтээгдэхүүнүүдийн нэг болох өрийн хэрэгслийн арилжааг идэвхжүүлэх, өрийн хэрэгсэл гаргах орчныг дэмжих зайлшгүй шаардлагатай юм. Хөрөнгийн зах зээлд өрийн хэрэгсэл гаргах нь банкны зээлээс хямдаар санхүүжилт татах, хөрөнгө оруулагчдын хувьд хадгаламжийн хүүгээс өндөр хувиар мөнгөө өсгөх боломжийг олгосноор бүх оролцогчдод харилцан ашигтай байдаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байх шаардлага тавигддаг бөгөөд энэхүү санамж бичиг байгуулагдсанаар хуулийн холбогдох шаардлагыг хангахгүй байгаа бизнес эрхлэгчид Зээлийн батлан даалтын сангаас олгох батлан даалтын тусламжтайгаар өөрт шаардлагатай санхүүжилтийг бүрэн татах боломж бүрдэх юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОPEC: Газрын тосны гарцаа нэмэхгүй

ОPEC-ийн гишүүн орнууд гарцаа нэмэхгүй гэдгээ мэдэгдсэний дараа газрын тосны ханш сүүлийн хоёр сарын дээд цэгт хүрч өсөөд байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп үнийг буулгахын тулд ОPEC-ийн орнуудад гарцаа нэмэх шаардлага тавиад байсан юм. Хэдий тийм боловч ОPEC-ийн орнууд хэрэглэгчид хүсэлт тавихаас нааш гарцаа нэмэх боломжгүй гэсэн шийдвэр гаргаад байна. Улмаар 8-р сарын дунд үед доод цэгтээ хүрээд байсан үетэй харьцуулахад газрын тосны ханш 10 орчим хувиар өсөөд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Монголбанк: IX сард 2.1 тонн алт худалдан авсан

Монголбанк 9-р сарын алт худалдан авалтын дүн мэдээг албан ёсоор танилцууллаа. Төв банк есдүгээр сард 2.1 тонн алт худалдан авсан байна. Ингэснээр Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ оны эхний есөн сард өссөн дүнгээр 14.3 тоннд хүрлээ. Хэдий тийм боловч Төв банкны худалдан авсан алтны хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 378 кг-аар буурсан үзүүлэлт болж байна. Алт тушаалтыг нэмэгдүүлэхийн тулд татварын хөнгөлөлтийг 2019 оноос цааш үргэлжлүүлэх саналыг Төв банк гаргаж байгаа юм. 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөлд тусгасан онцлох зорилтын нэг нь гадаад валютын албан нөөцийг дунд хугацаанд хамгийн багадаа 6.5 тэрбум ам.долларт хүргэх зорилт байгаа юм. Учир нь 7-р сарын байдлаар Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2.9 тэрбум ам.доллар байна. Энэ нь импортын бараа үйлчилгээний 5.2 сарын хэрэгцээг хангах хэмжээ юм. Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хэмжээнээс 43 хувиар доогуур, богино хугацаат өр төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй буюу олон улсын жишиг түвшнээс 10.4 нэгж хувиар бага байгааг Төв банк онцолж байна. Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээний нэг чиглэл нь Төв банкны алт худалдан авалт болж байна.

2018 онд Монголбанк 22 тонн алт худалдан авах зорилт тавьсан бөгөөд ингэснээр алт худалдан авалтаар гадаад валютын албан нөөцийг 700-800 сая ам.доллараар зузаатгах боломжтой гэдгийг онцолж байна.

Мөн үнэт металлын сорьцын хяналтын лабораторийг Дархан-Уул, Баянхонгор аймагт нээж, үйл ажиллагааг нь 10-р сард эхлүүлэх болсныг Төв банк мэдээллээ.

Ингэснээр иргэн, аж ахуйн нэгж олборлосон алтаа тухайн бүс нутагтаа сорьцлуулах боломжтой болж байна. Мөн алтны нийлүүлэлт нэмэгдэх боломжтойг Төв банк мэдээллээ. Лабораторийг байгуулахад 793.8 сая төгрөг төсөвлөгдсөн байна. Үүнээс 694 сая төгрөг нь тоног, төхөөрөмж худалдан авахад зарцуулагджээ.

Төв банк иргэд, аж ахуйн нэгжээс алтыг Лондоны Үнэт металлын биржийн ханшаар худалдаж авч байгаа аж. Дэлхийн зах зээлд алтны спот ханш он гарснаас хойш 10 хувиар унаж, 1,183 ам.долларт хүрээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Зохицуулах үйлчилгээтэй хүнсний нэр төрөл өргөжиж, зах зээл тэлж байна

ХХААХҮЯ-аас мэдээлснээр хоол хүнсний зохистой хэрэглээний 40 гаруй хувийг үр тариа, будаанаас хангадаг байна.

Сүүлийн жилүүдэд гурилан бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, ялангуяа бүхэл үр, маалингийн гурилаар хийсэн талх, нарийн боов, жигнэмэг зэрэг шинэ бүтээгдэхүүнийг олон компани үйлдвэрлэх болжээ. Тухайлбал, "Талх чихэр" компанийн гаргасан "Онцгой" нэрийн коллекц энэ төрөлд хамаарч байна. 80 гаруй нэр төрлийн талх, нарийн боов үйлдвэрлэдэг тус компани зохицуулах үйлчилгээтэй хүнсний түүхий эдийг дотоодоос гадна ОХУ, БНХАУ, Польш, Малайзаас авдаг аж. Зохицуулах үйлчилгээтэй хүнсний зах зээлд томоохон үйлдвэрлэгчдээс гадна жижиг, дунд үйлдвэрүүд олноор бий болж, өрсөлдөөн нэмэгдэж байгааг тус компани мэдээллээ.

Мөн энэхүү зах зээлийг дагаад үйлдвэрлэгчид хөх тарианы гурил, бүхэл үрийн гурил, хивэг орсон зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Зохицуулах үйлчилгээтэй хүнс хурдан муудах эрсдэлтэй байдаг учраас эргэлт хурдан байх ёстой гэж "Веж арт натуралс" ХХК онцоллоо. Өдөрт 2000 уут, найман төрлийн зохицуулах үйлчилгээтэй жигнэмэг үйлдвэрлэдэг тус компани жигнэмгээс гадна 15 төрлийн веган торт хийдэг байна. Түүхий эдийн хувьд бүхэл үрийн гурилыг "Милл хаус", "Алтан тариа" ХХК-аас овьёос, маалингийн гурил, харин гурвалжин будааны гурилаа ОХУ-аас импортлодог аж. Тус компани ирэх 11 дүгээр сараас тусгай бүтээгдэхүүнүүд зах зээлд гаргахаар зэхэж байгаагаа мэдээлсэн юм.

Транс тос, нөөшлөгчтэй бүтээгдэхүүнийг хүмүүс өдөр тутамдаа хэрэглэхээс татгалзах болсон энэ үед хэрэглэгчдийн худалданавалт цаашидуламбүрнэмэгдэнэгэж "Монфүүдланд" компани үзэж байна. Тус компани "Мовьёос" өглөөний хоол, "Цэнэглэгч" нэрийн овьёосон шахмал бүтээгдэхүүн, овьёосны зутан, бантан, гурил, талх зэргийг үйлдвэрлэж байгаа ажээ. Үйлдвэрээ өргөтгөн шинэ шугам тавихаар төлөвлөж буй тус компани ирэх оноос бүтээгдэхүүнээ экспортлохоос гадна түүхий эд овьёосыг 100 хувь дотоодоосоо хангах зорилт тавиад байгаа талаар мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

УУХҮЯ: Тавантолгойн коксжих нүүрсийг Тамань далайн боомтоор гуравдагч зах зээлд гаргана

Хар тэнгисийн Тамань далайн боомтоор Тавантолгойн коксжих нүүрсийг боловсруулан, гуравдагч зах зээл рүү экспортлоход хамтран ажиллахаар болсон тухай Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар ОХУ-д айлчлах үеэрээ тус боомтоор зочилж "Таманийн нурмаг ачааны терминаль" төслийн талбайд зочилж, газрын тосны агуулах, ачилт, овоолгын станцууд, туузан дамнуургын барилга угсралтын ажилтай танилцсан байна. Мөн айлчлалынхаа хүрээнд тэрбээр "Роснефть" компанийн Гүйцэтгэх захирал И.И.Сечинтэй уулзаж, газрын тосны чиглэлээр хамтран ажиллах ажлын хэсэг байгуулжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Төсвийн орлогын 26 хувийг уул уурхайн салбар бүрдүүлжээ

8-р сарын байдлаар төсвийн нийт орлогын 26 хувийг уул уурхайн салбараас бүрдүүлсэн байна. Тухайлбал, "Эрдэнэс Таван толгой" компани оны эхний найман сарын байдлаар улсад 222.6 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 40 гаруй хувиар өссөн үзүүлэлт болж байна. Харин "Оюу Толгой" компани тайлант хугацаанд 275.4 тэрбум төгрөгийн татвар төлсөн нь өмнөх оны мөн үеэс 37 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Дээрх хоёр компанийн төлсөн татварын хэмжээ уул уурхайн салбарын төвлөрүүлсэн татварын 30 орчим хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлж буй орлого сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа аж. Тухайлбал, 2013-2015 онд уул уурхайн салбар төсвийн орлогын 21-22 хувийг бүрдүүлж байжээ. Харин эрдэс бүтээгдэхүүний үнэ унасан 2016 онд хувь хэмжээ нь буурч 16 хувьд хүрсэн бол 2017, 2018 онд эргээд өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний үнэ унасан 2016 онд улсын төсөв 3.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарч байсан юм. Тайлант хугацаанд төсвийн нийт орлого, тусламжийн дүн 6.4 их наяд төгрөг хүрчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ВI: Олон улсад ам.долларын ханш чангарч, хөгжиж буй орнуудын валютын ханш унаж байна

Холбооны Нөөцийн банк 2015 оноос хойш мөнгөний бодлогоо чангатгах бодлого баримталж байна. Энэ он гарснаас хойш АНУ-ын Төв банк бодлогын хүүг хоёр удаа өсгөсөн юм. Мөн энэ долоо хоногт дахин өсгөх хүлээлт зах зээлд өндөр байгааг шинжээчид онцолж байна. Энэ онд БНХАУ болон АНУ-ын хоорондын худалдааны маргаан хурцдаж, хоёр улс импортын бараа бүтээгдэхүүний тарифаа нэмэгдүүлэх шийдвэр гаргасан юм. Худалдааны маргаан ийнхүү даамжирч байгаатай зэрэгцээд олон улсын валютын захад ам.долларын ханш голлох зургаан валютын эсрэг сүүлийн хагас жилийн хугацаанд 5.3 хувиар өсөөд байна. Харин ам.долларын ханш олон улсад чангарснаар Азийн орнуудын валютын ханш, ялангуяа хөгжиж буй орнуудын валютын ханш хамгийн их хэмжээгээр унаж байгаа аж. Тухайлбал, Аргентины песо болон Туркийн лирийн ханш он гарснаас хойш ам.долларын эсрэг 40-50 хувиар унаад байна. Өөрөөр хэлбэл энэ он гарсаар үнэ цэнэ хоёр дахин алджээ. Мөн Индонезийн рупиагийн ханш унаж сүүлийн 20 жилийн доод түвшинд хүрээд байна. 2018 онд нийт 146 улсын валютуудаас 100 гаруйнх нь ханш ам.долларын эсрэг унажээ.

Энэ дунд монгол төгрөг ч мөн багтаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, ам.долларын эсрэг төгрөгийн ханш 3.8 хувиар унаад байна. Хамгийн сүүлийн байдлаар ам.долларын албан ханш 2,520 төгрөгийг даваад байгаа юм. Энэ онд худалдааны тэнцлийн ашиг хангалтгүй, импортын өсөлт хөрөнгө оруулалтын дүнг давж байгаатай холбогдуулан ам.долларын эрэлт зах зээлд нэмэгдсэнийг Төв банк мэдээлж байв. Мөн он гарснаас хойш Төв банк хагас тэрбум ам.долларын интервенц хийгээд байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Монголд анхны цахим мөнгө нэвтэрч эхэллээ

Үндэсний төлбөрийн системд "Цахим мөнгө"-ний шинэ төлбөр тооцооны хэрэгслийг нэвтрүүлэх ёслолын арга хэмжээ Монголбанкинд өнөөдөр боллоо.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан хэлэхдээ, "УИХ-аас Үндэсний төлбөрийн системийн тухай хууль баталснаар манай улсад цахим мөнгө гаргах хууль эрхзүй бүрдэж Төвбанкнаас дээрх хуулийг мөрдөх "Цахим мөнгөний тухай" журам боловсруулснаар "Мобиком" группийн харьяа "Мобифинанс" ББСБ-д "Цахим мөнгө гаргах" тусгай зөвшөөрлийн анхны гэрчилгээ олгож Монголын анхны цахим мөнгө "Candy"-гээ гаргаж байна. Ингэснээр "Candy" нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгтэй адилтгах үнэ цэнэ бүхий бэлэн бус төлбөрийн хэрэгслээр тооцогдох боллоо.

Үүний өмнө манай улсын төлбөрийн системд зөвхөн арилжааны банкууд оролцдог байсан бол одоо санхүүгийн финтек үйлчилгээн дээр суурилсан ААН, компани, санхүүгийн байгууллагууд орж ирэн үйл ажиллагаа явуулж оролцох эрхтэй болж буй"-г онцлож байв. Тэрээр өнөөгийн зуун аж үйлдвэржилтээс мэдээллийн технологид, түүнийг дагасан цахим хөгжилд шилжиж байна. Дэлхийн олон улс орон, тэдгээрийн төвбанкууд цахим мөнгөний хэрэгсэлд шилжиж буй дэлхийн хөгжил дэвшлийн чиг хандлагаас Монгол Улс хоцрохгүй явах учиртайг тэмдэглэж байлаа.

Анхны цахим мөнгө гаргах хүсэлтийг санхүүгийн олон компани, ААН журмын дагуу Монголбанкинд ирүүлснээр шаардлагын дагуу судалж анхны зөвшөөрлийг "Мобифинанс" ББСБ-д олгожээ. Үүний цаана хоёр ААН хүсэлтээ ирүүлээд буйг Монголбанкнаас мэдээллээ. "Мобифинанс"-ийн хувьд "Мобиком"-ын үүрэн холбооны сүлжээн дээр тулгуурлан анхны дижитал санхүүгийн төлбөрийн хэрэгслийг олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр нэвтрүүлэхээр болж, түргэн шуурхай, хариуцлагатай ажиллахаа мэдэгдэж байна. "Мобиком" корпорацийн ерөнхий захирал Тацуяа Хамада, "Технологийн дэвшил дээр суурилсан цахим мөнгө нэвтэрснээр удахгүй бэлэн мөнгөний АТМ болон цахим карт халаагаа өгөх цаг ирж байна" гэв. "Candy" нь анх зөвхөн "Мобиком"-ын хэрэглэгчдэд зориулан бүтээсэн урамшуулал олгох лоялти хөтөлбөр байсан бол өдгөө Монгол орон даяар аль ч операторын хэрэглэгч ашиглах боломжтой цахим мөнгө буюу үндэсний төлбөрийн системд Монголбанкаар баталгаажсан цоо шинэ төлбөрийн хэрэгсэл болж байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.